



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Л.Равдандорж Утас: 70523020 Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-С/256

танай _____-ны № _____-т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Д.ЦЭНДМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

010020020

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	90.8	108.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,648.7	3,454.3
	Нийт хөрөнгийн дүн	3,739.5	3,562.8
	Нийт өр төлбөрийн дүн	2.3	0.4
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,737.2	3,562.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,739.5	3,562.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,946.8	1,021.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,147.6	1,264.8
	Үйл ажиллагааны үр дүн	2,799.2	-243.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	0.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,799.2	-243.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	938.0	3,805.8
	Тайлант оны үр дүн	2,799.2	-243.4
	Эцсийн үлдэгдэл	3,737.2	3,562.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	983.2	884.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	969.0	872.2
	Үйл ажиллагааны ЦМГ	14.1	4.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-14.1	-4.3
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.1	7.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.1	7.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	868.6	843.3
	Урсгал зардал	868.6	843.3
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	837.6	856.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	32.8	0.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зорилго: Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино

Чиг үүрэг: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулах.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар ахмадын сангийн үйл ажиллагааг байгууллагын үндсэн үйл ажиллагаатай хамт санхүүгийн үйл ажиллагааг бүртгэж, тайлагнасан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 123 мэдээлэл, хугацаа хоцроосон 23, хугацаа болоогүй 3 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээллийн цахим сайтад байршуулсан мэдээллүүд нь үнэн зөв алдаагүй байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг авч үзэх.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 191.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 183.4 сая төгрөгийн алдааг залруулж, 4.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 4.2 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

6.1 Залруулсан алдаа

1. Санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан нийт 72.8 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн.
2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй газрыг 103.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан.
3. Санхүүгийн тайланд ахмадын сангийн 7.6 сая төгрөгийг хамт тайлагнасан байна.

6.2 Албан шаардлага

Харилцагч байгууллагаас нэхэмжилсэн төлбөрийг барагдуулахдаа хэмнэгдсэн зардлын үлдэгдлүүдээс эдийн засгийн ангилал зөрчиж нийт 4.0 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

6.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Цалин, хөдөлмөрийн хөлсний бодит тооцооллыг данс бүртгэлт тусгаагүй өглөг, авлага үүсгэсэн байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Цалингийн тооцооллыг данс бүртгэлд тусгаж, санхүүгийн тайлан, мэдээг үнэн зөв гаргаж байх.

2. Орлоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Данс андуурагдаж хийгдсэн, болон алдаатай ажил, гүйлгээг үйл ажиллагааны орлого, зардлаар тайлан мэдээнд тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, 22 дугаар зүйл 22.5-д "Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг тус тус зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжид заасан хэм хэмжээг баримтлан Төсвөөс гарсан зардал, залруулгын гүйлгээг орлогоор хүлээн зөвшөөрөхгүй байх, холбогдох данс бүртгэлд цэвэрлэх бичилтийг хийж бодит гүйцэтгэлээр үнэн зөв тайлагнаж байх.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 121 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "...ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгийг... акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нь нөхсөн ... эд хөрөнгийн үнийг ...зөвшилцөн тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, эсхүл дахин шинээр үнэ тогтоох асуудлыг шийдвэрлэх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	7	191.6	3	183.4	-	-	1	4.0	3	4.2
	НИЙТ	7	191.6	3	183.4	-	-	1	4.0	3	4.2